



БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ

1989 оны 00
сарын 23 өдөр

дугаар 40

Улаанбаатар
хот

Бассейнтай 100 хүний халуун
усны талаар авах арга хэм-
жээний тухай

Сүхбаатарын районд баригдаж ашиглалтанд орж буй 100 хүний
бассейнтай халуун усны газар хөдөлмөрчдөд усан сан, уураар
үйлчлэх шинэ нэрийн үйлчилгээ хийж эхэлсэнтэй холбогдуулан
Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Нэг ээлжинд 100 хүнийг үйлчлэх хүчин чадалтай бассейн-
тэй халуун усны газрыг "Баян бүрд" халуун ус гэж нэрлэсүгэй.

2. Хотын "Баян бүрд" халуун усны газарт уурын ванн, усанд
орж байгаа хүмүүст нэг хүнд I шил хүртэл пиво-оор үйлчлэхийг
зөвшөөрсүгэй.

3. Дээрх халуун усны үйлчилгээнд зориулан пиво, ундааг
үйлчлэх хүмүүсийн тоонд тохируулан олгох, жилийн хэрэгцээг
хавсралт хуваариас давуулахгүйгээр олгохыг Хотын төлөвлөгөөний
комисс /н.Бат/-г, пиво ундааг зөвшөөрсөн хуваарийн дагуу
гэрээ байгуулж шууд нийлүүлэхийг Архи пивоны комбинат /н.Ган-
төмөр/-д даалгасугай.

4. Пиво, ундаагаар үйлчлэх ажилд тавих хяналтыг сайжруулан
өндөр зохион байгуулалт, дээд зэргийн дэг журамтай ажиллуулахыг
халуун усны захиргаа /н.Сүхээ/-д хариуцуулсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА *[Signature]* С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА *[Signature]* Д.АЛГИА



Хотын АДХ-ын гүйцэтгэх захир-
гааны 1989-2-23-ны 40-р тог-
тоолын хавсралт

100 ХҮНИЙ БАССЕЙНТАЙ ХАЛУУН УСАНД
ХӨДӨЛМӨРЧДӨД ХУДАЛДААЛАХ ПИВО,
УНДААНЫ ХУЬААРЬ

Худалдаалах зүйлийн нэр		Тоо хэмжээ	Бүгд	Улирлаар			
				I	II	III	IV
Пиво	Пиво	мян.л	35,0	8,0	9,0	10,0	8,0
	Үйлчлэх хүн	мян.хүн	70,0	16,0	18,0	20,0	16,0
Ундаа	Ундаа	мян.л	300,0	70,0	80,0	80,0	70,0
	Үйлчлэх хүн	мян.хүн	600,0	140,0	160,0	160,0	140,0